



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 17 өдөр

Дугаар А/136

Номгон

Г Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл
ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл
түдгэлзүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль 10 дугаар зүйлийн 10.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.21 дэх заалт, Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн комиссын 2022 оны 02 дугаар сарын 23-ний өдрийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1."Түвшин сэтгэшгүй" ХХК-ний 3135454 регистрийн дугаартай "Намуун" ЭХ-19/03/001 дугаартай Сэтгэцийн өвчний эрт үеийн оношилгоо, эмчилгээ, сэтгэл заслын клиник эмнэлгийн тусгай зөвшөөрлийг 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдрөөс 3 сар хүртэлх хугацаагаар түдгэлзүүлсүгэй.

2. Дурдсан хугацаанд Эрүүл мэндийн газар, Мэргэжлийн хяналтын газраас тавигдсан зөрчлийг арилгах ажлыг зохион байгуулж ажиллахыг "Түвшин сэтгэшгүй" ХХК-ний захирал (Ц.Цэцэгмаа)-д үүрэг болгосугай.

3. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл түдгэлзүүлсэн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн газар (Н.Энхжаргал), Мэргэжлийн хяналтын газар (Н.Бямбадорж) нарт тус тус үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамжийн хэрэгжилтийг мөрдүүлэхэд удирдлага арга зүйгээр хангаж, хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Наранбаяр)-т даалгасугай

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН



601220441